

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 9 дүгээр сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	/тоогоор/			
		2010-VIII	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-IX
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	136			136
3	Даатгалын төлөөлөгч	1998			1998
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	10			10
7	Бусад		1 <sup>1</sup>		

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

1<sup>1</sup>.Хорооны даргын 2010 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 133 дугаар тушаалаар “Прайм женерал даатгал” ХХК-ийн оноосон нэрийг “Тэнгэр даатгал” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 9 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

#### Ердийн даатгалын компаниудын хувьд :


№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-IX	2010-IX
1	Даатгалын нийт хураамж	1,687,824,860.3	1,998,400,879.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	494,006,180.8	439,695,889.7
3	Давхар даатгалд төлсөн хураамж	755,714,131.5	669,422,827.3
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	4,708	10,997

5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	7,140,000,000.0	69,534,624,329.4
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	70,455,840.0	21,389,100.0

2010 оны 9 дүгээр сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 310.6 сая төгрөгөөр өсч, олгосон даатгалын нөхөн төлбөр 54.3 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж 86.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 42.6 хувь буюу 284.9 сая төгрөгийг “Миг даатгал” ХХК, 32.8 хувь буюу 219.6 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, 20.5 хувь буюу 137.2 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 3.4 хувь буюу 23.0 сая төгрөгийг “Ард даатгал” ХХК, 0.5 хувь буюу 3.2 сая төгрөгийг “Практикал даатгал” ХХК, үлдэх 0.2 хувь буюу 1.3 сая төгрөгийг “Тэнгэр даатгал” ХХК тус тус шилжүүлсэн байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-IX	2010-IX
1	Даатгалын нийт хураамж	5,346,703.5	9,258,294.3
2	Олгосон нийт нөхөн төлбөр	632,000.0	10,714,865.7
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	6,820,928.0
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	9	4
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		2

	-Байгууллагын хугацаат даатгалд		1
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		1
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	30,000,000.0	5,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	480,000.0	6,165,445.7

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 9 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 3.9 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 10.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

### Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2010-VII	2010-VIII	2010-IX
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	31,686,601.0	40,106,149.5	33,275,321.4
2	Даатгалын зуучлагчийн орлого	13,987,318.7	18,341,972.8	14,192,906.4
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	302	22	60
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10,487,981,062.0	15,959,225,000.0	3,650,768,510.9

2010 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 60 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучлан 14.2 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын зуучлагч компаниудын орлогын 38.3 хувь буюу 5.4 сая төгрөгийг “Аме” ХХК, 18.7 хувь буюу 2.6 сая төгрөгийг “Лоялти солюшн” ХХК, 16.7 хувь буюу 2.4 сая төгрөгийг “Эм жи ай би” ХХК, 14.0 хувь буюу 1.9 сая төгрөгийг “Ачит ундарга” ХХК, 11.8 хувь буюу 1.7 сая төгрөгийг “Асимон брокерс” ХХК төвлөрүүлэн ажиллаж, “Скай эрдэнэ” ХХК, “Жомолхари” ХХК даатгалын зуучлалын орлогогүй байна.

### 3.БУСАД МЭДЭЭЛЭЛ :

1.Хорооны Ажлын албаны даргын баталсан 2010 оны шалгалтын төлөвлөгөөний дагуу Хорооны даргын баталсан удирдамжаар 2010 оны 9 дүгээр сарын 13-наас 27-ны өдрүүдэд “Практикал даатгал” ХХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн.